



БАТЛАВ.  
МАЛ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГА А.НАРАНТУЯА

## ИТГЭМЖЛЭЛИЙН СУРГАЛТ ЭРХЛЭХ БАЙГУУЛЛАГА СОНГОН ШАЛГАРУУЛАХ УРИЛГА

Сонгон шалгаруулалтын нэр: 2024 онд малын эмч нарын итгэмжлэлийн сургалт зохион байгуулах байгууллагын сонгон шалгаруулалт

Сонгон шалгаруулалтын дугаар: СЭБСШ – 01/2024

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/385 дугаар тушаалаар батлагдсан “Төгсөлтийн дараах үргэлжилсэн сургалт явуулах болон малын эмчид итгэмжлэл олгох, түдгэлзүүлэх, цуцлах журам”-ыг үндэслэн малын эмч нарт итгэмжлэлийн сургалт зохион байгуулах тул сургалт эрхлэх байгууллагын сонгон шалгаруулалтад оролцохыг урьж байна.

Сургалт эрхлэх байгууллага нь Мал эмнэлгийн ерөнхий газраас баталсан хөтөлбөрийн дагуу доор заасан байршилд сургалт зохион байгуулна. Үүнд:

- Байршил-1. Улаанбаатар хот
- Байршил-2. Зүүн бүс
- Байршил-3. Баруун бүс

Сургалт эрхлэх байгууллагад тавигдах шаардлага:

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/385 дугаар тушаалаар батлагдсан “Төгсөлтийн дараах үргэлжилсэн сургалт явуулах болон малын эмчид итгэмжлэл олгох, түдгэлзүүлэх, цуцлах журам”-ын 3.1, 3.3, 3.4-д заасан шаардлагыг тус тус хангасан байна.

№	Тавигдах шаардлага	Нотлох баримт
1	Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтээ албан ёсоор илэрхийлсэн байх	Байгууллагын удирдлагын албан бичиг
2	Байгууллагын үйл ажиллагааны чиглэл нь сургалт зохион байгуулах үйл ажиллагаанд нийцсэн, эрх зүйн чадамжтай хуулийн этгээд байх	<ul style="list-style-type: none"><li>- Хуулийн этгээдийн Улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар /Хэрвээ түншлэлээр оролцож байгаа бол хамтран ажиллах түншлэлийн гэрээ, түншлэлд багтаж байгааг бүх гишүүн байгууллага эрх зүйн чадамжтай болохоо тус бүрдээ нотолно/;</li><li>- Улсын бүртгэлийн гэрчилгээнд сургалт эсхул судалгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар бүртгэгдсэн байх;</li></ul>
3	Сургалтын ажиллагаа байсан үйл явуулж туршлагатай байх	<ul style="list-style-type: none"><li>- Сургалтын сэдэв, огноо, зорилтот бүлэг, багш нарын нэр болон захиалагчтай холбоо барих мэдээллийг багтаасан жагсаалт;</li><li>- Сүүлийн 3 жилд зохион байгуулсан 3 хүртэл сургалтын жагсаалт, сургалт тус бүрийн товч танилцуулга /гэрэл зураг оруулсан бол зураг тус бүр тайлбартай байна/</li></ul>

4	Шаардлага хангасан сургалтын анги танхимтай байх	- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, эсхүл сургалтын танхим түрээсээр ашиглах албан ёсны гэрээний хуулбар хувь; - Анги танхимын дотор болон гадна талаас авсан 4 ширхэгээс доошгүй гэрэл зураг;
5	Сонгосон хөтөлбөрөөр сургалт зохион байгуулахад шаардлагатай хэрэглэгдэхүүн, техник хэрэгсэлтэй байх	- Сургалтын хэрэглэгдэхүүн, техник хэрэгслийн нэр, зориулалт, хүчин чадлыг тодорхойлсон жагсаалт; - Техник хэрэгсэл тус бүрийн гэрэл зураг;
6	Сонгосон хөтөлбөрөөр сургалт зохион байгуулах мэргэшсэн баг бүрдүүлсэн байх	- Үндсэн болон гэрээгээр ажиллах багшийн А4 хэмжээний нэг хуудаст багтаасан товч танилцуулга (CV); - Багш тус бүрийн хөдөлмөрийн гэрээ, эсхүл хөлсөөр ажиллах гэрээний хуулбарыг хавсаргах.

Хэд хэдэн байгууллага хамтран түншлэл хэлбэрээр санал ирүүлж болно. Энэ тохиолдолд түншлэгч байгууллагууд хамтран ажиллах түншлэлийн гэрээ, толгойлох байгууллагаа сонгосон тухай албан ёсны шийдвэрийг баталгаажуулж ирүүлнэ.

Сонгон шалгаруулалтад оролцох сонирхолтой байгууллага /Хуулийн этгээд/ нь дээрх шаардлагыг хангаж байгааг нотлох баримтыг бүрдүүлж, 2024 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө Мал эмнэлгийн ерөнхий газарт албан бичгээр ирүүлж, мөн цахим хувилбарыг [trainingcommission@vet.gov.mn](mailto:trainingcommission@vet.gov.mn) хаягаар дээрх хугацаанд ирүүлнэ. Заасан хугацаанаас хоцорсон саналыг хүлээн авахгүй.

Санал ирүүлж байгаа байгууллага сургалтын хөтөлбөрийн агуулга, эзэмшүүлэх мэдлэг чадварын хүрээг баримтлан дараах мэдээллийг нэмэлтээр оруулж, саналд хавсарган ирүүлнэ. Үүнд:

- Байгууллагын нэр;
- Сургагч багш нарын мэдээлэл;
- Сургалтын сэдэвчилсэн төлөвлөгөө;
- Мэдлэг шалгах сорилын тест;
- Сургалтын төлбөрт хөнгөлөлт үзүүлэх эсэх мэдэгдэл;

Санал бэлтгэх хугацаанд лавлах, тодруулга авах шаардлагатай тохиолдолд [trainingcommission@vet.gov.mn](mailto:trainingcommission@vet.gov.mn) хаягаар болон утас 51-262482 (Өрөөний дугаар-29)-тай холбогдоно уу.

**Санал ирүүлэх хаяг, хүлээн авах албан тушаалтан:** Мал эмнэлгийн ерөнхий газрын Бичиг хэргийн ажилтан (Өрөөний дугаар:32, Утас:267633)

Энэхүү сонгон шалгаруулалтад оролцогчдоос ирүүлсэн саналыг хянан магадлах, нэмэлт тодруулга авах, үнэлэх ажлыг Мал эмнэлгийн ерөнхий газрын Сургалтын комисс хийж гүйцэтгэнэ. Үнэлгээний үр дүнгийн талаарх мэдэгдлийг санал хүлээн авч, хамгийн сүүлчийн нэмэлт тодруулга авсан өдрөөс хойш ажлын 5 хоногт багтаан Мал эмнэлгийн ерөнхий газраас бүх оролцогчдод мэдэгдэнэ.

**МАЛ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР**